



“Татварын сайн тогтолцоо гэж юу вэ?”

Татварын “сайн” тогтолцоо гэж юу вэ? Татвар төлөх нь хэнд ч сайхан санагддаггүй. Гэвч төсвийн орлогыг бүрдүүлэгч томоохон эх үүсвэр нь татвар байдаг. Цаашлаад, нийгэмд шаардлагатай нийгмийн болон биет дэд бүтцийг бий болгоход улс хариуцлага хүлээдэг. Бид татварын орлогогүйгээр сургууль, эмнэлэг, зам зэргийг бий болгох боломжгүй юм.

Татварын “сайн” тогтолцооны үндсэн ухагдахуун нь энгийн, эрх тэгш байхад тулгуурлана. Үүнийг дараах утгаар ойлгоно:

- Хөндлөн эрх тэгш байдал - ойролцоо орлоготой иргэд ижил түвшинд татвар төлөх
- Босоо эрх тэгш байдал - илүү орлоготой иргэд бага орлоготой иргэдээс илүү хэмжээний татвар төлөх

Аж ахуйн нэгж, байгууллага татвар төлдөг боловч эцсийн дүнгээр иргэд түүнийг төлдөг. Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн үйлчилгээний хөлсөнд татварыг оруулан тооцож, түүнийг зөвхөн цуглуулах үүрэгтэй юм. Тиймээс татварын бага хувь, өргөн бааз суурьтай байх нь зүйтэй. Эдийн засгийн харилцаанд орж буй бүхий л иргэд, аж ахуйн нэгжүүд өөрт ногдох татварыг төлснөөр татварын бааз суурь хамгийн их байх юм. Татварын онцгой хөнгөлөлт, чөлөөлөлт, албан бус эдийн засаг татварын баазыг багасгахад нөлөөлж бусдад татварын дарамт учруулахад хүргэдэг.

Татварын “сайн” тогтолцоог мөрдүүлэхэд хялбар байдаг. Татварын хууль, тогтоомж нь бүгдэд нээлттэй, ойлгоход хялбар, тооцоход хүндрэлгүй байх ёстой. Татварын мэдээллийг бэлтгэн, түүнийг цуглуулахад улсад нэмэлт дарамт учрах ёсгүй. Төвөгтэй татварын хууль нь түүнийг мөрдөх, цуглуулахад үр ашиггүй тогтолцоог бий болгон татвар төлөгч болон улсаас нэмэлт зардал гаргахад хүргэдэг.

Аж ахуйн нэгжүүд татвараас зугтах, эсхүл бизнесийн зохисгүй шийдвэр гаргахад муу бичигдсэн татварын хууль нөлөөлдөг. Үүний нэг жишээ нь хоёр шатлалтай татварын хувь, хэмжээ юм. Зарим аж ахуйн нэгжүүд татварын дээд шатлалд орохоос зайлсхийн олон жижиг хараат компанийг үүсгэн байгуулж байна. Энэ нь эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэн, ажлын байр бий болгоход муугаар нөлөөлж байна.

УИХ-ын намрын чуулганаар татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хэлэлцэнэ. Дээрх үндсэн ухагдахуунууд үүнд тусгалаа олсон байх ёстой.

Энэхүү мэдээлэл нь татварын шинэчлэлийн талаар нийт ард иргэдийн санаа бодлыг сонсох зорилгоор Сангийн яам, Үндэсний Татварын Ерөнхий Газраас явуулах “Татварын илэн далангүй яриа” сэдэвт цуврал хэлэлцүүлгийн дөрөвдүгээр хэсэг юм. Та бүхэн татварын шинэчлэлийн хуулийн төслийн англи, монгол хувилбарыг “Нээлттэй засаг” вэб сайт (www.open-government.mn), Сангийн яамны вэб сайт (www.mof.gov.mn), ҮТЕГ-ын вэб сайт (www.mta.mn)-аас үзэж, саналаа ирүүлж болно.